

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

ҮНДЭСНИЙ ИХ БАЯР НААДМЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Үндэсний их баяр наадмын тухай хуульд дараах агуулгатай хэсэг, заалт нэмсүгэй:

1/9 дүгээр зүйлийн 9.3.6, 9.3.7 дахь заалт:

“9.3.6.улсын арслан цолтой бөх ес даван түрүүлбэл улсын аварга;
9.3.7.улсын аварга цолтой бөх ес даван түрүүлбэл улсын даян аварга;”

2/21 дүгээр зүйлийн 21.5 дахь хэсэг:

“21.5.Аймгийн баяр наадам, түүнтэй адилтгах баяр наадмын бөхийн барилдаанд шөвгөрсөн бөхөөс допингийн шинжилгээг 2025 оны баяр наадмаас эхлэн авна.”

2 дугаар зүйл. Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.5 дахь хэсгийн “аймгийн арслан цол олгоно.” гэсний дараа “Аймгийн тэгш ойн баяр наадамд 256 бөх барилдаж болно.” гэж, 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсгийн “дөрөв, түүнээс дээш давсан бөх,” гэсний дараа “9.5-д заасан аймгийн баяр наадам, түүнтэй адилтгах баяр наадмын бөхийн барилдаанд шөвгийн дөрөвт үлдсэн бөх,” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл. Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.8 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“9.8.Улсын баяр наадамд түрүүлж, үзүүлэж, шөвгөрсөн бөхчүүдийн эрэмбийг Монголын үндэсний бөхийн холбооны дүрмээр зохицуулна.”

4 дүгээр зүйл. Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3.6 дахь заалтын дугаарыг “9.3.8” гэж, 9.3.7 дахь заалтын дугаарыг “9.3.9” гэж, 9.3.8 дахь заалтын дугаарыг “9.3.10” гэж, 9.3.9 дэх заалтын дугаарыг “9.3.11” гэж, 9.3.10 дахь заалтын дугаарыг “9.3.12” гэж, 9.3.11 дэх заалтын дугаарыг “9.3.13” гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл. Энэ хуулийг 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

ХӨДӨЛМӨРИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Хөдөлмөрийн тухай хуулийн 97 дугаар зүйлийн 97.1.6 дахь заалтын “11,” гэснийг “10, 11,” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг